

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.БОЛОРМАА

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.”, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүн бүр “эрүүл, аюулгүй орчинд амьдрах...эрхтэй”, 6 дахь хэсэгт “эрүүл мэндээ хамгаалуулах...эрхтэй” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол¹-оор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.3.4-т “...мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна.”, 3.4.4.3-т “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлнэ.”

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол²-оор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2-т “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” гэсэн зорилтыг тусгаж хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.8-т “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.”, 2.2.35-т “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна.” гэж;

Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.3-т “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ” гэсэн зорилтыг тусгаж хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.3.2-т “Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй,

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2010, №36

² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №25

тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, ...хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана.” гэж тус тус заасан.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Мансууруулах эмийн тухай" 1961 оны нэгдсэн конвенцод 1990 онд, "Сэтгэцэд нөлөөт бодисын тухай" 1971 оны конвенцод 1999 онд, "Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг" 1988 оны конвенцод 2001 онд тус тус нэгдэн орж, соёрхон баталсан.

Мөн Монгол улс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай 1989 оны конвенцод 1990 онд нэгдэн орж хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлыг Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг олон хууль тогтоомжоор зохицуулсан байна.

1.2.Практик шаардлага

Монгол улс нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан бөгөөд 2011, 2025, 2021, 2022, 2023, 2024 онуудад нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл³-ээс дурдвал Монгол улсад хар тамхи мансууруулах бодисын хэрэглээний талаар анхны судалгааг 1990 онд хийж 45 хэрэглэгчийг илрүүлж байсан бол 2000-2006 оныг хүртэл жил дараалан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад хар тамхи мансууруулах бодисын хэрэглээний талаар судалгаа хийхэд хэрэглэгчдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдсээр 410 хэрэглэгчийг илрүүлсэн байна.

Тухайн үед мансууруулах бодисын хэрэглээ нь рок, поп, хип хоп чиглэлийн олны танил дуучин, чинээлэг, боломжийн амьдралтай айлын хүүхдүүд хэрэглэн, танилын хүрээллээр дамжуулан зарж борлуулдаг байсан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой 2017 онд 90 гэмт хэрэгт 116 этгээд холбогдож байсан бол 2019 онд 258 гэмт хэрэгт 317 болж 2.7-2.9 дахин нэмэгдсэн байна. Харин 2021 онд 187 гэмт хэрэгт 210 этгээд холбогдон шалгагджээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт ял эдэлж байгаа этгээд 2017 онд 24 байсан бол 2020 онд 183, 2022 оны 8 дугаар сарын байдлаар 103 болжээ. Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбогдох гэмт хэргийн илрүүлэх, таслан зогсоох уйл ажиллагаа сайжирсан, нөгөө талаар иргэдийн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдох нь огцом нэмэгдсэн гэж дүгнэхээр байна.

Улсын хэмжээнд хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг 2002-2007 оны хооронд 1 жилд дунджаар 8 гэмт

³ Цагдаагийн ерөнхий газраас УИХ-ын гишүүн Х.Болормаад 2025 оны 6 дугаар сарын 23-ны №01/849 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэл


хэрэг бүртгэгдэн шалгагдаж байсан бол 2015-2025 оны хооронд нийт 1966 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Хүснэгт №1. 2017-2024 оны хугацаанд бүртгэгдсэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоо, мэдээ

Он	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
Гэмт хэрэг	79	94	222	200	258	204	187	230	238	254	1966
Холбогдогч	169	221	255	265	344	292	240	269	280	301	2636

Энэхүү мэдээллээс үзэхэд 2017 оноос хойш хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоо, мэдээ өмнөх жилүүдээс 2-3 дахин өсөж хар тамхи, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хэрэглэгчдийн тоо ихсэж, хууль бус эрэлт, нийлүүлэлт нэмэгдэж, бодисын төрөл зүйл олширч тус гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч эхэлсэн байна.

График №1. 2015-2024 оны хугацаанд бүртгэгдсэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоо, мэдээ




Дээрх графикаас харахад 2020-2021 оны хооронд (Ковид-19) цар тахлын улмаас хөл хорио тогтоосон нь гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлсөн ч 2022 оноос энэ төрлийн гэмт хурдацтай нэмэгдэж, нөхцөл байдал улам бүр хүндэрч байгааг харуулж байна.

Улсын хэмжээнд 2015 оноос хойш Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой нийт 1966 гэмт хэрэг бүртгэгдэж, 2636 холбогдогч шалгагдсан байна.

Шинэчлэн баталсан Эрүүгийн хууль 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш буюу сүүлийн 8 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой 1793 гэмт хэрэгт 2246 холбогдогч бүртгэгдсэний 1977 буюу 88.0 хувь нь эрэгтэй, 269 буюу 12.0 хувь нь эмэгтэй байна.

График №2. 2017-2024 оны хугацаанд бүртгэгдсэн зөрчлийн хэргийн тоо, мэдээ



Зөрчлийн тухай хуулийн 5.1.3-т заасан мансуурсан гэх үндэслэлээр улсын хэмжээнд 1313 иргэд холбогдсон нийт 1137 зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 1054 зөрчлийн хэрэг нээж, 83 зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 83,9 хувь буюу 955 нь нийслэлд, 15,1 хувь буюу 183 нь орон нутагт бүртгэгдсэн байна. Нийслэлд бүртгэгдсэн нийт зөрчлийн 28.5 хувь буюу 273 нь Баянзүрх дүүрэгт байгаа бол бусад нь алслагдсан дүүрэгт бүртгэгдсэн байна.

Зөрчилд гадаад улсын 3 иргэн холбогдсон бол давхардсан тоогоор 321 иргэд 2-5 удаа тухайн зөрчлийг давтан үйлдэж, хариуцлага хүлээлгэж, зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчлийг 3 иргэн тус бүр 5 удаа давтан үйлдсэн байгаа бол 2 удаа зөрчил үйлдсэн 97 иргэн бүртгэгдсэн байна.


Зөрчилд холбогдсон нийт иргэдийн 64,3 хувь буюу 845 иргэнд шүүгчийн захирамжаар баривчлах шийтгэл оногдуулсан бол 33,7 хувь буюу 443 иргэнийг эрх бүхий албан тушаалтны шийтгэврээр торгох шийтгэл оногдуулж, үлдсэн иргэдийг албадан сургалтад хамруулахаар шийдвэрлэжээ.

Сүүлийн 8 жилийн хугацаанд 1793 мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг бүртгэгдсэнээс 1527 буюу 86 хувь нь Нийслэл хотод, үлдсэн 245 буюу 14 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 269 буюу 12.0 хувь эмэгтэй, 1977 буюу 88.0 хувь нь эрэгтэй, үүнээс 1145 буюу 51 хувь нь 18-25 насны иргэд байгаа нь анхаарал татаж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас ирүүлсэн мэдээлэл⁴-д “сүүлийн үед залуучууд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтад ороогүй төв мэдрэлийн системд үйлчилдэг өвчин намдаах эм, тайвшруулах үйлчилгээтэй эмийг зүй бусаар хэрэглэж эрүүл мэнддээ эрсдэл учруулах тохиолдлууд ихсэж байна. Иймээс эдгээр эмүүдийг хянах шаардлага үүсээд байна” гэсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн ажилтан Б: “хэвийн журмаар худалддаг өвчин намдаах, ханиад анагаах эм зэрэг олноор хэрэглэвэл мансуурах боломжтой эмүүдийг тусгай журмаар худалдах эмийн жагсаалтад оруулах шаардлагатай”-г дурдаад 2022 онд 8 хүүхэд өвчин намдаах төрлийн эмийг олныг нухаад шингэнтэй хольж судсандаа шахсанаар хялгасан судаснууд бөглөрч улмаар нас барсныг тэмдэглэсэн байна⁵.

График №2. Мансууруулах бодист донтсон этгээдийн нийгмийн байдал 2014-2023 он. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвөөс ирүүлсэн мэдээлэл⁶



⁴ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас УИХ-ын гишүүн Х.Болормаад 2025 оны 6 дугаар сарын 30-ны №01/1314 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

⁵ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2023 он.

⁶ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2023 он.

Мансууруулах бодист донтсон этгээдийн дунд 0-15 настай хүүхдүүд 2016-2023 оны байдлаар нийт 36 тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ талаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Донтох эмгэг судлалын клиникийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч Б.Энхчимэг "Стрессээ тайлж сураагүй, гэр бүлийн эрүүл орчинд амьдраагүй, хайр энхрийлэлгүй орчинд өссөн хүүхэд аливаа зүйлд донтох нь элбэг байдаг. Үүнээс гадна тухайн хүүхдийг хамгаалах хүнгүй, эцэг, эхгүй гэдэг мэдрэмж нь ямар нэг донтолт үүсгэх магадлалыг нэмэгдүүлдэг. Өсвөр насныхан ямар нэг зүйлийг олон талаас нь харж чаддаггүй. Тиймээс ямар нөлөө авч байна түүндээ автах магадлал өндөр байдаг нь аюултай" гэж дурдсан байна⁷.

Дээрх тоон үзүүлэлтүүдээс үзэхэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын төрөл, хэлбэр олширч, шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөтэй бодисыг хилээр нэвтрүүлэх оролдлого нэмэгдэж байгаагийн сацуу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтад ороогүй хэдий ч төв мэдрэлийн системд нөлөөлөх үйлчилгээтэй өвчин намдаах төрлийн эм бэлдмэлийг хууль бусаар хэрэглэх тохиолдол гарч байна.

Мөн энэ төрлийн гэмт хэрэгт хүүхэд холбогдох, оролцогч, хохирогч болох байдал өсөн нэмэгдэж байгаа нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн улмаас хүн амын эрүүл мэнд, удмын санд ноцтой аюул нүүрлэж Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд харшилсан нөхцөл байдал үүсгэж байна.

Гучаас дээш насны иргэдийн зан төлөв, амьдрал ахуй нь тогтворжсон байдаг тул шинээр мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглэгч болох, аливаа хорт зуршилд уруу татагдах нь бага байдаг бол өсвөр насны хүүхэд, залуус мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх уруу таталтад амархан автдаг байна. Иймд энэ төрлийн гэмт хэргийг үйлдэгч нар өсвөр насны хүүхдүүдийг онилох, тэднийг зах зээл болгож бэлтгэх хандлага олон улсын түвшинд анхаарал татаж байдаг.

Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээг газар авхуулахгүй байх үүднээс хүүхдийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус гэмт хэрэгт татан оролцуулсан, хүүхдийг хохирогч болгосон тохиолдолд эрүүгийн хуулиар оногдуулах ял шийтгэлийг чангатгах шаардлагатай байна.

Эрүүгийн хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг тус хуулийн 20 дугаар бүлэгт заасан олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн төрөлд багтаан 20.7 дугаар зүйлд тусгаж ял шийтгэлийг зааж өгчээ.

Харин эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт хүүхдийн эсрэг гэмт хэргийн төрлүүдийг зүйлчлэн зааж өгсөн боловч тус хуулийн 16.2 дугаар зүйлд хүүхдийг

⁷ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2023 он.

согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах гэмт хэргийг дор дурдсан байдлаар зүйлчилсэн байна. Үүнд:

1. Хүүхдийг байнгын согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн 16.2 дахь зүйлийн 1 дэх хэсэгт хүүхдийг байнгын согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулсан бол торгох, эсхүл зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэх, 16.2 дахь зүйлийн 2 дахь хэсэгт энэ гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр тус тус зааж өгсөн нь хоёр өөр төрлийн гэмт хэргийг нэг зүйл ангид багтааж, хүүхдийг мансуурах, донтох байдалд татан оруулсан гэмт этгээдэд оногдуулах ял шийтгэлийг сулруулах үндэслэл болж байна.

Иймд эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн 16.2 дахь зүйлээс мансуурах, донтох байдалд татан оруулах гэмт хэргийг салгаж тус хуулийн 16 дугаар бүлэгт шинэ зүйл анги нэмэн энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг тодорхой зааж өгөх шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Энэхүү хуулийн төсөлд гэмт хэрэг болгон өөрийн гэсэн онцлог шинжтэй байдгийг харгалзан үзэж хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, үйлдсэн гэмт хэрэгтээ тохирсон ял шийтгэл эдлэх ёстой гэсэн шударга ёсны зарчимд нийцүүлэн ял шийтгэлийг тодорхой зааж өгнө.

Түүнчлэн шүүх мансуурах, донтох байдалд татан оруулах гэмт хэрэг бүрт тохирсон ял шийтгэл оногдуулах боломжийг олгох үүднээс гэмт хэргийг эрүүгийн хуульд заасан ангиллын дагуу зааглах, хорих ялын доод, дээд хэмжээг холдуулах бодлогыг баримтлана.

Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

Эрүүгийн хуулийн 16.2 дугаар зүйлд заасан хүүхдийг мансуурах, донтох байдалд татах оруулах гэмт хэргийн төрлийг хүүхдийг байнгын согтуурах байдалд татан оруулах гэмт хэргийн төрлөөс салгаж тусад нь 16.12 дугаар зүйл шинээр нэмнэ.

Шинээр нэмэх 16.12 дугаар зүйлд хүүхдийг мансуурах, донтох байдалд татан оруулах гэмт хэрэг үйлдсэн бол, энэ гэмт хэргийн улмаас хүүхдийн эрүүл мэнд, амь нас хохирсон бол, энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол оногдуулах ял шийтгэлийг чангатгаж тус тусад нь зааж өгнө.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийн шийдвэрлэх арга хэмжээний талаар

Эрүүгийн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн зорилго нь хүүхдийг мансуурах, донтох гэмт хэрэгт татан оруулсан бол түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхой болгох явдал юм.

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар хүүхдийг мансуурах, донтох байдалд татан оруулсан, энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн, энэ гэмт хэргийн улмаас хүүхдийн эрүүл мэнд, амь нас хохирсон бол оногдуулах ял шийтгэл чангарна.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн нэмэлт ачаалал үүсэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал өсөх зэрэг эдийн засгийн үр дагавар гарахгүй.

Мансуурах, донтох гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдэх, хүүхдийг хохирогч болгосон тохиолдолд оногдуулах ял шийтгэлийн бодлогыг чангатгах нь хүүхдийг энэ төрлийн гэмт хэргийн улмаас учрах хор хөнөөлөөс хамгаалах, цаашлаад хүн амын удмын санг хамгаалахад нөлөө үзүүлж нийгэмд эерэг үр дагавар авчирна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1-д “Доор дурдсан хууль тогтоомжийн төслийг дараах хууль санаачлагч санаачилна:... 36.1.2... эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга...-ийн төслийг зөвхөн Засгийн газар санаачлах” гэж заасан.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь анхдагч хууль, шинэчилсэн найруулгын төсөлд хамаарахгүй тул Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нийцүүлэн энэхүү хуулийн төслийг боловсруулсан.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд нийцсэн бөгөөд “үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, хүн бүр “эрүүл, аюулгүй орчинд амьдрах...эрхтэй”, “эрүүл мэндээ хамгаалуулах...эрхтэй” гэж тус тус заасан тул хүүхдийг гэмт халдлагаас хамгаалах, хүүхдийг мансуурах, донтох гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх,

хүүхдийг гэмт хэрэгт татан оруулсан гэмт этгээдэд оногдуулах ял шийтгэлийг чангатгах нь хууль зүйн бүрэн үндэслэлтэй байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ